

“ХЭЛ ЗОХИОЛЫН БҮС НУТАГ СУДЛАЛ БУЮУ НУТГАРХАЛ СУДЛАЛ БОЛ ШИНЖЛЭХ УХААН МӨН”

*Лариса Владимировна Полякова,
Российская Федерация. “Вопросы литературы”, Москва. 2015, №3*

Манай эх орны утга зохиол шинжлэлд орон нутаг судлалын “цаг хугацаа - орон зайн нийлэг дүрт шинж” /”хронотопической образности”/, “орон нутгийн шинжтэй дүр” /образом местности”/, “орон нутаг судлаач”, /”местнограф”/ гэх мэт утга зохиол шинжлэлийн нийгэм - түүхийн аргагүйн баримт материалуудад ач холбогдол өгөх явдал сүүлийн жилүүдэд онцгой идэвхжиж байна. Тухайлбал, Н.Корниенко “утга зохиолын дурсгалууд буюу түүхэн үйл явдлуудыг үнэн зөв, бодитой тайлбарлах үзэл баримтлал” өөд шилжих тухай бичсэн. /Корниенко.Н.В. “От редактора. Филология прошлого и будущего” Анциферов.Н.П. “Проблемы урбанизма в русской художественной литературе. Опыт построения образа города - Петербурга Достоевского - на основе анализа литературных традиций”.

Москва. ИМЛИ. Российская Академия Наук. 2009. С.10/ Утга зохиолын тухай шинжлэх ухааны энэхүү шинэхэн салбар хэрхэн идэвхжиж байгааг Оросын Шинжлэх Ухааны Академийн дэргэдэх А.М.Горькийн нэрэмжит Дэлхийн утга зохиолын хүрээлэн дээр 2012 оны 9-р сард зохион байгуулагдсан “Москва дахь Анциферовын анхдугаар уншлага”, 2013 оны 9-р сард Оросын Шинжлэх Ухааны Академийн дэргэдэх Дэлхийн утга зохиолын хүрээлэн болон Утга зохиолын Улсын музей хоёр хамтран зохион байгуулсан “Москва дахь Анциферовын хоёрдугаар уншлага” зэрэг олон улсын хурал зөвлөгөөнүүд онцгой тод харуулсан билээ. /смотрите: Н.П.Анциферов “Филология прошлого и будущего” По материалам международной научной конференции “Первые московские Анциферовские чтения” 25-27 сентября 2012 г. Москва. ИМЛИ. Российская Академия Наук. 2012/ /Вторые московские Анциферовские чтения. Сб.ст. по материалам Международной конференции, посвященной 140 летию В.Д.Бонч - Бруевича. 12-14 сентября 2013 года. Москва. Три квадрата. Государственный литературный музей. 2014/

Өнөөдөр энэ чиглэлээр тусгайлсан өгүүлэл, түүвэр, ганц сэдэвт зохиол тэрчлэн эрдмийн зэрэг горилсон судалгааны ажил хүртэл бичигдэж, хэвлэгдээд байна. Тамбовт 2009 оноос мэргэжлийн судалгааны болон мэдээлэл - задлан шинжилгээний “Хэл зохиолын бүс нутаг судлал”

/”Филологическая регионалистика”/ сэтгүүл, мөн Курскт хэл зохиолын бүс нутаг судлалын “Курскийн үг” хэмээх шинжлэх ухааны судалгааны лаборатор ажиллаж байна. 1920-иод онуудад “Петербург маягийн бичвэр” /”Петербургский текст”/ хэмээх үзэл бодлыг идэвхтэй, нээлттэй шүүн хэлэлцэж байсан бөгөөд Н.Анциферовын бичиж тэмдэглэснээр нэр томьёо судлалд орж ирсэн энэхүү нэр томьёогүйгээр өнөөдөр бид бүхэн В.Топоровын судалгаагаар Оросын утга зохиолд орж ирж нутагшсан “москвагийн”, “пермийн”, “елецкийн”, “воронежийн”, “оросын”, “германы”, “лондоны”, “ромын”, “флоренцийн”, “крымийн”, “сибирийн”, “дорны”, “европын” гэх мэт домог зүйн яруу найраг болон утга зүйн судалгаан дахь аргуудад дэвшүүлсэн томьёоллуудыг ойлгохын аргагүй билээ. Тэрчлэн Томскийн их сургуульд шинжлэх ухааны энэхүү шинэ дэг сургууль хэлбэржин хөгжиж, олон тооны судалгааны ажил, орон нутгийн хотуудын “бичвэр”, тэрчлэн зэрэг горилсон зохиолууд бичигдэж байна.

Энэ тохиолдолд утга зохиол судлаачдын хэл шинжээчдээс ялгагдах ялгаа нь судалгаанд ашиглаж буй бичвэрүүдээ “орон нутгийн шинжтэй дүрүүд” - ийн тухай асуудалд зохицуулж, бичгийн хэлбэрт оруулсан тэмдгүүдийн уялдаа холбоо бүхий бүтэц гэж үздэгт орших бөгөөд хэл шинжээчдийн “бичвэр” хэмээх ойлголтын тухай ямар нэг тодорхой тайлбарыг нэг их дагаж мөрддөггүй юм.

Бүр 1970 онд Ю.Лотман шинжлэх ухаан дахь сонирхолтой үзэгдлийнх нь хувьд “бичвэр” /”текст”/ хэмээх ухагдахуун нь “үсгээр дүүргэсэн үхмэл зүйл биш харин амьд эзэлхүүн ба амьд хөдөлгөөн” гэж тэмдэглэж байсан билээ. /Лотман.Ю.М. “Структура художественного текста” М. Искусство. 1970. С.203/ Хэдийгээр өнөө цагт, энэхүү сэдвээр их зүйл бичиж байгаа боловч мөн түүнчлэн сайтар бодож тунгаагүй, энэхүү нэр томьёог бүдэгдүүлж, илэрхий будлиантуулсан зүйл ч бас тааралдаж л байна. Энэ нь шинжлэх ухааны мэдлэгийн ашиг тусыг хүлээн авах явцыг ихээхэн хүндрүүлдэг. Утга зохиол судлал дахь “бичвэр” хэмээх нэр томьёо нь хэдийгээр утга зохиол шинжлэлийн сэтгэлгээний сонгодог уламжлалд “бичвэр” болон “уран сайхны зохиол” хоёрын зааг ялгааг бүрэн төгс хатуу чанд байдлаар

зааглан ялгадаггүй боловч утга зохиол судлал дахь “бичвэр” хэмээх нэр томъёог басхүү харилцан зөвшилцөж болох адил төстэй ойлголт ухагдахуун гэж тооцож болохгүй. /смотрите: Лихачев.Д.С. “О филологии” М. Высшая школа. 1989. С. 27-30, Бахтин.М.М. “Проблема текста в лингвистике, филологии и других гуманитарных науках. Опыт философского анализа” Бахтин.М.М. “Вопросы литературы и эстетики” М. Художественная литература, 1975./

Ямар ч гэсэн “зөвхөн тухайн газар нутгийн бичвэр” буюу орон нутаг судлалын мэдээ занги бүхий уран зохиол дахь бодит баримтуудыг судлан үзэх шаардлагатай гэдэг нь маргашгүй. **“Хэл зохиолын бүс нутаг судлал буюу нутгархал судлал”** хэмээн нэрлэгдэж буй шинжлэх ухааны зэрэгцсэн чиглэл зүй ёсоор бүрэлдэн тогтож, шинээр хэлбэржиж буй тухай асуудал тавигдаж байгаа нь зайлшгүй билээ.

Анциферовын эрдмийн зэрэг горилсон зохиол нь “Оросын уран зохиол дахь хотжилтын асуудлууд: Утга зохиолын уламжлалыг задлан шинжлэх үндсэн дээр дүгнэж үзвэл: Достоевскийн Петербург бол хотын дүр бүтээх туршлага мөн” хэмээх сэдэвтэй байсан бөгөөд 1944 онд Олон улсын Утга зохиол Урлагийн Хүрээлэнд хамгаалж, дөнгөж 2009 онд л хэвлэгдсэн юм. Тийм учраас чухам одоо л нийгмийн бодит байдлыг тов тодорхой болгох нь тэргүүн зэргийн ач холбогдолтой гэж сургадаг Анциферовын хэсэгчилсэн /тухайн орон нутаг - С.Э/ түүхэн судалгааны аргад тулгуурлан утга зохиол - уран сайхны баримтуудыг судлах өвөрмөц онцгой энэ аргазүйг үүсгэн буй болгох яг цаг нь билээ. Аргазүйн ийм төрөл нь зохиолчдыг тухайн бүс нутагтай нь холбон судлахад чиглэгдэнэ. Эдгээр арга зүй нь зохиол дахь дүрүүдийн нэр овог, хэв шинж, газар нутгийн нарийвчилсан тусгай нэршлээр дамжин илрэх үйл явдлын тогтолцоо, туурвилзүй, зохиолын зан төрх, агуулга зэргээр дамжин тодорхойлогддог. Чухам тэр үед Анциферовынхоор бол “судлагдаж байгаа хотын хүн амын өвөрмөц онцлог тодорхойлолт” болон “хотын оршин суугчдын ухамсар, тэдний ажил төрлийн онцлог дээр суурилсан тухайн орон нутгийн засаг захиргаа-эрх мэдэл”-ийн тухай, мөн түүнчлэн тухайн газар нутгийн бичвэрийн тухай ярих бололцоо гарч ирдэг. /Анциферов.Н.П. Указ. соч.с.16/

Жишээ нь: Платоновын нэрлэсэн “Тамбовын хүн”-ий амьдралын хурц тод дүр зургийг дараах зохиолуудын хуудаснаас төсөөлөн ойлгож болно. Үүнд: Державины уран бүтээлийн

тамбовын үед хамаарагддаг жүжгүүд болон уянгын яруу найраг, Лермонтовын “Тамбовын нярав эмэгтэй”, Баратынскийн Мар-т байх үедээ бичсэн “Тамбов нутаг дахь Стенькин аянгын нижигнээн”, Терпигоревын “Хомсдол. Тамбовын газрын эзний бодол эргэцүүлэл, ба тэмдэглэлүүд”, Жемчужниковагийн “Хагацлын дуу”, “Хөгширлийн дуу”, Сергеев - Ценскийн “Харамслын тал”, Замятины “Хушуунд тохиолдсон явдал”, Платоновын “Градуудын хот”, Серафимовичийн “Москва дахь Тамбов эр”, Цветаевагийн “Эрх чөлөөт галт тэрэг”, Виртийн “Ганцаардал”, тэрчлэн Солженицыний “Би”, “Кочетовка зөрлөг дээр тохиолдсон явдал”. Чухам эдгээр зохиол бүтээлүүдийг хэл зохиолын бүс нутаг буюу нутгархал судлалын хүрээнд, хэсэгчилсэн - түүхэн арга зүйн үзэл баримтлалуудыг ашиглан задлан шинжилж болно.

“Тодорхой хатуу тогтолцоонд байгаа ойлголтуудыг дахин шинээр өрөхийн тулд шинжлэх ухаан ертөнцийг /байгаа байдлыг - С.Э/ эхлээд бутаргадаг”, “шинжлэх ухааны барилга барьдаг цорын ганц материал нь “ойлголт” гэдэг тоосго мөн” гэж А.Потебня цохон тэмдэглэсэн байдаг. /А.А.Потебня “Эстетика и поэтика” М.Искусство.1976.с.194-195/ Анциферовын нээлтийн шинжтэй шинэ сургаалтай холбогдуулан “хэл зохиолын бүс нутаг буюу нутгархал судлал” хэмээх ойлголтынагуулгыг тодорхойлох оролдлого хийж, манай эх орны орон нутаг судлаачид асар их ажиллаж буй бөгөөд мөн шинжлэх ухааны энэхүү чиглэлийн нэлээд хэдэн үзүүлэлтүүд аль хэдийнээс салангид тархай бутархай байдалтай байсан боловч “утга зохиол шинжлэлийн орон нутаг судлал” хэмээх ойлголтын хүрээнд өөрийн үндсэн үүрэг, мөн чанарыг хадгалан үлдсэн байдаг. /Травушкин Н.С. “Литературное краеведение в системе литературоведческих наук” Астрахань 1967, Куприяновский.Н.В. “Проблемы регионального изучения литературы” Русская литература 1984. №1, Милонов.Н.А. “Литературное краеведение” М. Просвещение. 1985, Андреев.В.Е. “Литераторы в Тамбовской земле” Липецкое Изд. Госкомпечати.1998, Егорова.Л.П. “История литературы Ставрополя. 20 век”. Ставрополь. Изд. Северо-Кавказского федерального университета. 2012/

Анциферовын “хэсэгчилсэн - түүхэн” /”локально - историческому”/ аргад хандахдаа бид хамгийн түрүүнд: түүхчид болон хэл шинжээчдийн бичсэн урлаг дахь “хотын” хүчин зүйлсийн тухай ерийн бус байдлыг бодолцох нь зайлшгүй чухал басхүү юуны өмнө ”хотын утга

зохиол судлалд аугаа их хот гэдэг нэрийг хүртсэн” /Анциферов.Н.П. Указ. соч. с.16/ тийм хотын тухай бичлэгт тулгуурлан задлан шинжлэх аргагүйг буй болгосон тэрхүү өвөрмөц шинэ нэр томьёо, гүн ухааны өвөрмөц шинэ үзэл баримтлал, өвөрмөц шинэ учир зүйн баримтууд зэрэг өөрийн гэсэн шинэ тогтолцоо бүтээснийг тооцож үзэх хэрэгтэй.

Анциферовын бодлоор хотын дүр болон хотын түүхэн тодорхой дүр байдал нь жишээ нь Петербургийн дүр гэдэг нь зохиолд уран сайхны олон төрлийн үүрэг гүйцэтгэж буй гоозүйн янз бүрийн тэмдэгтүүд юм. Хотын дүр гэдэг бол нэг ёсондоо утга зохиолын баатрууд эсвэл нарны дүр, байшингийн дүр, цэцэрлэгийн дүр гэдэг шиг тийнхүү ерөнхийлөн дүгнэсэн утга зохиол - уран сайхны нэг тийм ай/категория/ юм. Энэ тохиолдолд хотын дүр нь утга зохиолын уламжлалыг бүтээх, мөн орон нутгаа шүтэх үзэл санааны хил хязгаарыг даван туулахад нь зохиолчид зөвшөөрөл олгодог тийм гол санааг ерөнхийлөн дүгнэх зэрэг тодорхой зорилтот үүргийг гүйцэтгэдэг бөгөөд харин судлаачдын хувьд зохиолчдын өөрсдийнх нь ертөнцийг үзэх үзэл, уран сайхны танин мэдэхүй зэрэг нийтлэг асуудлуудын хүрээнд тэдний зан чанар, байр суурь зэргийг харьцуулах бололцоо боломжийг судлаачдад олгодог. Өөр өөр үндэстний утга зохиол болон соёлын янз бүрийн үе шатны төлөөлөгчдийн тэрчлэн гоозүйн янз бүрийн дүр сонирхолтой уран бүтээлчдийн зохиолуудыг задлан шинжлэх үндсэн дээр энэхүү орон нутгархаг үзлийн илрэлүүдийг мөрдөн мөшгөж, нээн илрүүлж болно.

1986 онд Дон дахь Ростовт Зөвлөлт - Америкийн хамтран зохион байгуулсан “Михаил Шолохов ба Уильям Фолкнер” сэдэвт бага хурлын илтгэлүүд “Дон” сэтгүүлийн хуудаснаа хэвлэгдэн гарсан. Тэр үед П.Палиевский дэлхийн утга зохиолын тэрхүү хоёр сонгодог зохиолчийг хамтад нь “XX зууны утга зохиолын санаанд оромгүй асуудлууд буюу хамгийн сонирхолтой асуудлуудын нэг” гэж нэрлэсэн билээ. /”Михаил Шолохов и Уильям Фолкнер”. Материалы советско - американского симпозиума. Дон. 1987. №5. с. 128-138./ Нэг илтгэгч Т.Индж “Тэр хоёр хоёулаа газар эдэлбэрийн ахуйд өсөж төрсөн, бага залуудаа хэд хэдэн мэргэжил сольсон, өөрсдийн уран бүтээлийн үйл ажиллагааг өгүүллэг бичиж эхэлсэн, хамгийн гол бүтээлүүд нь 1920 - 1930-аад онд бичигдсэн” гэдгийг онцлон тэмдэглэж байв. Хэдийгээр хоёулаа тогтолцоотой боловсрол эзэмшээгүй ч гэсэн мөн л хоёулаа Нобелийн шагнал хүртсэн. Тэд бие биенийхээ тухай огт мэддэггүй байхдаа орчин цагийн түлхүүр

асуудлуудын талаар болон хүний өөрийнх нь хамгийн гүн дотоод мөн чанарын тухай адилхан л санаа тавьж, адилхан л бичиж туурвидаг байсан: “хүн гэдэг амьтан зөвхөн тэсдэг төдийгүй бас ялан дийлдэг” /Фолкнер/, “хүн эцгийн мөрөн дээр тулж өндийгөөд, өсөж том болон, цаашид бүхнийг тэвчин, өөрийн замд учирсан бүхнийг даван туулж чаддаг” /Шолохов/. Палиевскийн бодлоор “энэ хоёр зохиолч хоёулаа өөрсдийн ард түмний гүнээс төрөн гарч, өөр өөрсдийн ард түмний түүхийн үнэт зүйлс, туйлын хүслэнг дүрслэн тусгахын тулд туйлын энгийн биеэ авч явсан.”, “хоёр зохиолчийн амьдралын хэв шинж ч маш эгэл энгийнээрээ адил төстэй байсан: тэдний хэнд нь ч Швейцарийн Альпийн нуруунд хааяа очиж суудаг харш байсангүй, хэнд нь ч сонсголонтой чамин гоё нэртэй дарвуулт завь байсангүй, хэнд нь ч үнэ цэнэтэй уран зураг, африкийн үнэт чулуу, шаазангийн чамин цуглуулга байгаагүй билээ. Тэд өөрсдөд нь хэрэг болдог, өөрсдийнх нь цорын ганц өмч болох морь, нохой, тамхины гаанс, загасны уурга, дэгээ, ангийн буу зэрэгтэйгээ хамт, өмнө нь найз нөхөд байсан тэр л хүмүүсийнхээ дунд үлдсэн билээ. Энэ бол мэдээж тэдний номуудын мөр бүхэнд дүрслэгддэг, нөгөө л байнгын дасал болсон эд зүйлс хийгээд байнгын тогтвортой амьдрал нь билээ.” /”Михаил Шолохов и Уильям Фолкнер”. Материалы советско – американского симпозиума/

Бага хурал дээр үг хэлсэн Палиевскийн дараа Т.Морозов ярихдаа бага эх орны тухай сэдвээр Шолохов болон Фолкнерийн адил төстэй шийдвэрт анхаарлаа хандуулсан юм: “...тэд XX зуунд эх орон гэдэг утга, үзэл санаа нь хүн төрөлхтнийг салгаж хөндийрүүлдэггүй харин ч нэгтгэж нягтруулдаг гэдгийг анх удаа нотлон харуулсан”, бөгөөд Шолоховын “Дөлгөөн Дон”-ы газар нутаг ба Фолкнерийн “төрөлх нутгийн шуудангийн бяцхан марк” нь түгээмэл утга учир агуулж байдаг билээ. Тэрчлэн тэдний бүтээлүүдэд байгалийн энгүүн сайхан амар амгалан дүр төрх, туульсын хүүрнэлийн тодорхой нарийн дүрслэлүүд тэрчлэн “Дөлгөөн Дон” болон “Йокнапатофа” хэмээх нэрүүдэд буй адил төстэй байдал зэргийг Морозов бас ажигласан байна. /Йокнапатофа – гэдэг нь индианчуудынхаар “гал газар гол ус намуухан урсана” гэсэн утгатай үг ажээ - Л.П/

Оросын болон Америкийн уран бүтээлчид утга зохиол дахь түгээмэл шинж болон орон нутаг шүтэх үзлийн хоорондын хил хязгаарыг “эзлэх” ба “байлдан эзлэх” хоёрын зааг ялгааг нураан арилгасан юм. Тухайлбал, орон нутаг шүтэх

үзлийг даван туулах үүргийг хотын дүр хүлээн авсан бөгөөд Анциферов өөрийнхөө судалгааны ажлынхаа өмнөтгөлд том нийсэл хотуудыг зэрэгцүүлэн задлан шинжлэх хоёр бололцоо боломж байгааг бичсэн байдаг. Үүнд: "...салангид тусдаа асуудлуудын зэрэгцээ Достоевскийн Петербургийн асуудлыг дэвшүүлэн тавих, оросын болон гадаадын гэх мэт бусад зохиолчдын тухайн сэдвээр бичиж шийдвэрлэсэн баримтуудыг зэрэгцүүлэн харьцуулах үндсэн дээр тэдгээр тус тусдаа асуудал нэг бүрийг боловсруулах. Хоёр дахь боломж нь: тийнхүү зэрэгцүүлэн харьцуулж үзэхдээ салангид тус тусдаа асуудлуудын үндсэн дээр биш харин янз бүрийн зохиолчдод бүгдэд нь байдаг хотуудын дүрийн хэв шинжид тулгуурлах" /Анциферов Н.П. Указ.соч. С.20-21/

Анциферовт өөрт нь энэ хоёр дахь арга нь илүү үр дүнтэй санагдсан байдаг: "Томоохон зохиолчдын бүтээсэн хотын дүр нь маш үнэмшилтэй байдаг бөгөөд түүний бүх нарийн ширийн зүйлс нь бүхэл бүтэн нэг амьд мөн чанараас урган гарсан байдаг. Салангид тус тусдаа асуудлуудыг зэрэгцүүлэн жишиж үзэх анхны арга нь тэрхүү бүхэллэг шинжтэй нэгдмэл дүрийг салгаж бутаргах явдал юм. Энэхүү сонголт нь хотын дүр хэмээх миний үндсэн сэдвээр нөхцөлддөг буюу түүний онцлогоос шалтгаалж байдаг: учир нь хотын дүр бол зохиолчийнх нь ертөнцийг үзэх бүх үзэл бодлоор дамжин, түүнийх нь нарийн төвөгтэй байдлын хэр хэмжээгээр тодорхойлогддог. Достоевскийн Петербург, Диккенсийн Лондон, Бальзакийн Парис зэрэг хотуудын дүрийн хооронд нийтлэг ерөнхий зүйл маш их байгааг харуулж болно." /Анциферов Н.П. Указ.соч. С.20-21/

Хэл зохиолын нутгархах үзэл судлал нь зөвхөн харьцуулсан дүн шинжилгээ хийдэг төдий биш басхүү тухайн зохиол бүтээлийг нийгэм - түүхийн нөхцөл байдал дунд нь зохиогчийнх нь өөрийнх нь амьдрал ахуй дунд нь, орон нутаг судлалын баримт хэрэглэгдхүүнүүдтэй нь холбон авч үзэж судлах явдал зайлшгүй чухал буюу энэ нь нэг ёсондоо судлаачийн зайлшгүй хүлээх нэг үүрэг билээ. "Уран зохиол дахь хотын хэв маягийг судлах асуудлуудад холбогдох баримтууд" хэмээх нэртэй зэрэг горилсон зохиолын удиртгалд, Анциферовын хотуудын тухай хэвлүүлсэн маш олон бүтээлүүдийн дунд "яруу найрагчид болон хүүрнэл зохиолчдын уран бүтээлд дүрслэгдсэн хотын дүр"-ийн судалгаатай холбогдуулж, хотын уран зохиолын асуудлуудад зориулсан судалгааны ажлууд онц чухал үүрэг ач холбогдолтой гэдгийг хичээнгүйлэн цохон тэмдэглэснийг дурдсан

байна. Ийм төрлийн ажлууд хоёрдмол зорилго тавьдаг. Хотын уран зохиол нь нэг талаасаа зохиолч, уран бүтээлчдийн өмнө хотыг судлах бололцоо боломжийг олгодог, нөгөө талаасаа тэрхүү бүтээсэн дүрүүд нь зохиогчийг өөрийг нь бүтээлч бие хүн талаас нь судлах өвөрмөц арга замыг нээж өгдөг. /Анциферов.Н.П. указ. соч.с.20-21/

Хэдийгээр энд Анциферов зөвхөн хотжилтыг судалдаг судлагдахуунаар хязгаарлан ялгамжаалж нэрлэдэг шинжлэх ухааны энэхүү нэр томъёог хэрэглээгүй боловч тэрхүү хэл зохиолын бүс нутаг судлал буюу нутгархал судлал гэж юу юм бэ? гэдэг асуултад тодорхой хариулт өгсөн юм. Харваас Анциферовын зорилт нь тэрхүү хэл зохиолын бүс нутаг судлал буюу хэл зохиолын нутгархал хэмээх үзэгдлийг жирийн нэг утга зохиолын орон нутаг судлалын зорилтоос хавьгүй өргөн хүрээнд тодорхойлон хэлбэржүүлэх явдал байжээ: "Достоевскийн Петербургийн жишээн дээр би утга зохиол /Анциферов.Н.П. Указ. соч. с. 20-21/ дахь хотжилтын асуудлуудын үндсийг нээн илрүүлэх оролдлого хийхийг хүсэж байна". Тэрчлэн хотжилтын асуудлуудыг шийдвэрлэхэд нутгархал шүтэх үзэл нь уран бүтээлчид болон утга зохиол судлаачид тодорхой түүхэн хотуудад хандах үед илэрч гарч ирдэг бөгөөд чухам тэр үедээ зөвхөн утга зохиол - уран сайхны асуудлуудыг шийдвэрлэдэг төдийгүй басхүү тухайн орон нутаг судлалд хамааралтай мэдлэгийг хуримтлуулдаг.

Утга зохиолын сонгодгуудыг судлахад хэл зохиолын бүс нутаг буюу нутгархал судлалын бололцоо боломжийн тухай асуудлуудын хүрээнд тэдгээр сонгодгуудын зохиол бүтээлүүдийн агуулга нь төдийлөн бүрэн төгс бус байсан ч хамаагүй тэдгээрт дүрслэгдсэн тухайн цаг үеийн хотжилтын түүхэн бодит байдлын дүрслэлд анхаарлаа хандуулж, хамтатган судлах нь үр дүнтэй байж болно. Жишээлбэл, М.Лермонтовын "Тамбовын нярав бүсгүй" хэмээх найраглал дахь түүний утга санааны нарийн өнгө аяс, үндсэн бичвэрээс /текстээс/ гадуурх **антураж**, орос орны амьдралыг хүүрнэсэн тусгай жижиг хэсгүүд, тэдгээрийг илэрхийлсэн задлан шинжилгээ /губерний захирагч Бобковский өөрийн эхнэр Авдотья Николавна-тай хөзөр тоглож буй хэсэг/, хотын сэтгэл хөдөлгөсөн дүр зураглал г.м. Хөдөөгийн хотын төлөв байдал, оршин суугчдынх нь дүр төрх, ёс зүй, ёс суртахуун, үнэт зүйлсийнх нь онцлог, нийгмийн бүтэц бүрэлдэхүүн зэрэг тухайн газар нутгийн уран сайхны дүр төрхийг бүтээж буй тэрхүү уран чадвар нь бүтэц - туурвилзүйн яруу сайхан, хурц тод шийдэлд

биеллээ олсон байдаг. Их хотын орон зай, нутаг орны дүр төрхийг бүтээх үйл явцын зэрэгцээ басхүү нутгархах үзлийг шүтэн бишрэх явдлыг даван туулах зорилт ч статистикийн болон лавлах тоо баримтууд, тухайн үеийн засаг захиргааны хэвлэл мэдээллийн хэрэгслүүд дээр гарсан эх сурвалжууд тэрчлэн аж ахуйн болон сүм хийдийн данс тооцоо, аж үйлдвэрийн болон худалдааны салбарын үзүүлэлтүүд гэх мэт нийгэм - түүхийн баримтат гол шинжүүдийн туслалцаатайгаар энэхүү зохиолын хуудаснаа хэрэгжсэн байна. Яруу найрагч түүхэн хэсэгчилсэн хязгаарлагдмал хандлагыг сонгож авснаараа Анциферовын дэвшүүлсэн нэр томьёогоор бол “их хотын оюун санаа”, “их хотын оршин суугчдын ажил төрөл, хэрэг явдал, тэдний ухамсар оюун санаан дээр суурилсан нутгийн засаг захиргаа”, “судлагдаж буй хотын хүн амын өвөрмөц онцлог мөн чанар”-ыг гаргаж ирэх, өнөөдөр соёл судлал болон коммеморацийн арга гэж нэрлэгдэх болсон өнгөрсөн үеийн түүхэн хүмүүс, онцлог дүрүүд, чухал чухал үйл явдлуудаар дамжуулан өнгөрсөн үеийн амьдралын дүр зургийг сэргээн тогтоох, энэ бүхнийг уран сайхны туршлагад нэвтрүүлэх зэрэг бололцоо боломжийг олж авсан байна.

“Тамбовын нярав” зохиолд хотын дүрийг бүтээсэн нь уран сайхны маш их ач холбогдолтой үүрэг гүйцэтгэсэн байдаг. Зохиогч гол баатруудаа хаашаа ч гарах гарцгүй занганд орсон мэт, түгжигдмэл давчуу орон зайд баларч доройтсон нөхцөлд дүрсэлсэн бөгөөд мөхөж сүйрэх тавилантайгаар үйл явдал өрнөж, зохиол төгсдөг. Энэ үед их хотын нийгэм - ёс суртахууны өвөрмөц тодорхой онцлогтой танилцах явцад хөндлөнгийн зориулал маягаар цэцэн үг ашиглаж зохиогчийн хэлсэн “Тогло, харин булхайцалгүй тогло” хэмээх үг нь бидний баримтлах ёс суртахууны дүрэм болж ойлгогдож байна. Энэ яриа мэдээж ердөө л хөзөр тоглох үед л гарч ирдэг яриа боловч Лермонтовын зохиолууд дахь энэ тоглоом нь өөрөө бидэнд их хотын амьдралын нэг хэсэг, түүний өөрийн гэсэн өвөрмөц дүр төрх, давтагдашгүй нэг билэг тэмдэг маягаар ойлгогддог бөгөөд тэрчлэн хувь хүний амьдралын философи, зан чанар, ёс суртахууны зарчимууд, бусад хүмүүстэй харьцах харьцаа, юуны өмнө хүмүүсийн хоорондын харьцааг ч илэрхийлж байдаг.

Лермонтовын бүтээсэн хөдөөгийн хотын амьдралын дүр зураг нь Анциферовын тодорхойлсон “зохиогчийн өөрийнх нь уран бүтээлийн давтагдашгүй бодгаль шинжийг судлахад өвөрмөц арга барилаар” хандахад тохирсон задлан шинжлэх арга хэрэгсэл болж байна.

Утга зохиол шинжлэлийн судалгааны аргагүйг хэрэгжүүлэх явцад, ХХ зууны 20-30-аад онд ялангуяа хотын уран зохиолд болон орон нутгийн судалгааны баримтуудад анхаарал тавих явдлыг идэвхжүүлэх явдал онцгой ач холбогдолтой гэж Анциферовт санагдаж байсан байна. Зэрэг горилсон зохиолынхоо өмнөх үгэнд тэрээр бичсэн нь: “Хотуудыг сонирхох энэхүү дүрэлзсэн их сонирхлыг дэлхийн I дайнаар өдөөгдсөн их донсолгоонтой холбоотойгоор дэвшүүлэн тавих хэрэгтэй бөгөөд энэ нь дайнч германчуудын бидэнд авчирсан аймшигт дайны галын дэргэд ердөө л үзүүлэх сургууль шиг байсан билээ. Хүн төрөлхтөн өөрийн түүхэнд тохиолдсон аймшигт сүйрлээр нураасан бүхнийг эргүүлээд сэргээн босгох тэрхүү энх тайван цаг ирэх үед, сүйтгэгдэн зовж зүдэрсэн төрөлх хотоо сонирхох сонирхол зөвхөн хотынхонд ч биш басхүү ерөөс аймшигт сүйрлийн дараа тэсэж үлдсэн, манай гариг дэлхий даяар хөөгдөн туугдсан тэдгээр бүх хүмүүт шинэ эрч хүчээр дахин төрөх болно. Үүний хамт басхүү хотуудын “дүр төрхөд” татагдах сонирхол улам бүр цэцэглэн хөгжих бөгөөд тэр ч хэрээрээ их хотуудын дотоод мөн чанарт нэвтэрч, их хотуудын “оюун санаа”-г ойлгон ухамсарлахад хөнгөн хялбар байх болно.” (Анциферов, х. 15).

Нураагдан сүйтгэгдсэн бүхнийг хүний ухамсар оюун ухаанд эргүүлэн сэргээж тодруулах тухай өнөө цагт ихэд нийцэж тохирсон яриа нь зөвхөн хүсэл эрмэлзэл төдий зүйл биш билээ.

Өнөөдөр хотуудыг сонирхох сонирхол, өөрсдийн төрөлх хайрт бага эх орноо сонирхох сонирхол, ерөөс эх орныхоо түүхэнд хандах сонирхол нь бүхэлдээ орчин үеийн хүний өөрийнх нь сэргэн мандалт, өсөлт дэвшилтийн зайлшгүй нэг чухал нөхцөл, ёс суртахууны болон түүхийн үндэс суурь, баталгаа нь болсон байнам. Нөгөө талаас ямар ч асуудлыг өнөөгийн даяршлын үйл явцыг тооцохгүйгээр тусад нь авч үзэх бололцоогүй болсон байна. Тэрчлэн хүмүүнлэгийн мэдлэгийн даяршил нь урлагийн үзэл санааны агуулга болоод тухайн үндэстний мөн чанарыг тэгшитгэн устгах гол хүч болж хувирч байна.

Орчин үеийн нийгмийн ухамсрын дотоод /имманент/ бодит үйл явцын нөлөөн дор хүмүүнлэгийн ухааны сонирхол нь зүй ёсны үйл явц болж, зөвхөн нэгдмэл хэв шинжит дүр төрхтэй төдийгүй басхүү тухайн бүс нутгийн өвөрмөц тусгай явцуу онцлогт чиглэгдэж, орон нутгийн тухай мэдлэг болон бүс нутгийн нутгархал судлалыг танин мэдэх нэг гол эх сурвалж болж өгч байна. Ийм нөхцөлд “хэл зохиолын бүс нутаг судлал буюу нутгархал судлал” хэмээх шинжлэх

ухааны бүхэл бүтэн нэг шинэ чиглэл болох эл нэр томъёог баримтлах нь зүйд нийцэх бөгөөд хүмүүнлэгийн ухааны гэр бүлд орох өөрийн гэсэн байр суурь түүнд бүрэн бий.

Хэл зохиолын нутгархал судлалын зорилт бол нэг талаасаа хэлбичгийн ухааны нэг салбар бөгөөд нөгөө талаасаа зохиолчдын бүтээлч өвөрмөц бодгаль чанарыг ойлгож ухамсарлан, хэл шинжлэлийн арга хэрэгслүүдийг ашигласны үндсэн дээр тухайн бүс нутгийн хажуугийн соёлын /субкультуры/ үүсэл хөгжил, хувьсал, хэлний үйл явц болон утга зохиол - уран сайхны үзэгдлүүдийг тогтолцоотой судалсны үндсэн дээр гарч ирдэг түүхийн мэдлэг юм.

Хэл бичгийн нутгархал судлал нь хавсарга шинжлэх ухааны олон үүрэгт мэдлэгийн хүмүүнлэгийн нэг салаа мөчир бөгөөд даяаршил болон язгуурын төрмөл чанар хоёрын хоорондын зөрчил улам бүр өсөн нэмэгдэж буй энэ цаг үед түүний түүхэн үүрэг бүр ч амин чухал шаардлагатай болж байна. Хэл бичгийн нутгархал судлал нь утга зохиол шинжлэлийн орон нутаг судлал болон хэл шинжлэлийн аман аялгуу судлалд ордоггүй. Харин тэрээр /хэлбичгийн нутгархал судлал - С.Э/ соёлын давтагдашгүй өвөрмөц /феномен/ харилцаа болж байдаг тухайн оршин суугаа газар нутгийн түүхийн судалгаан дахь шинжлэх ухааны олон салбар хоорондын үйл явцыг идэвхжүүлэх боломжийг хангаж өгдөг бөгөөд тэрчлэн нэр судлал /ономастик/ болон газрын нэр зүй /топонимика/, амьтны нэршил /анималистики/, мөн амьд ярианы хэл, угсаатны асуудлууд зэрэг тухайн үндэстний бүр төрөлхийн язгуур мөн чанарын гүнд хүртэл нэвтэрч тухайн нутаг орны бодит байдлын онцлогийг өргөн хүрээтэй хамран судлахыг санал болгодог билээ.

Хэл бичгийн нутгархал судлалын зорилтыг шийдвэрлэх нь: хэл зохиолын судалгааны урлаг эзэмшсэн хэн бүхний тэрчлэн түүхчид болон хэл шинжээчдийн эрхэм үүрэг, нэр хүндтэй даалгавар, заяа тавилан гэж хэлж болно. Аливаа уран бүтээлд хандах нийгмийн үнэт зүйлсийн хандлага нь эрин цаг үеийн ёс суртахуун - оюун санааны болон нийгмийн үнэлэмжийн асуудлуудад хариулт өгч байдаг бөгөөд газар орны уран сайхны зураглалыг тусган харуулж, зохиогчийн тухай болон өөрөө өөрийнхөө тухай тэрчлэн цаг хугацааны талаар нийгмийн ач холбогдол бүхий ямар нэгэн мэдээлэл өгч байдаг. Хэрэв М.Гаспаровын байгалийн шинжлэх ухаан хүн төрөлхтнийг өлсөж үхэхгүй байхад зориулагддаг бол хүмүүнлэгийн ухаан түүнийг өөрөө өөрөөсөө болж сөнөж мөхөхгүй байхад үйлчилдэг хэмээсэн

гайхалтай хурц, ухаалаг харьцууллыг санавал хэл зохиолын бүс нутаг судлал нь зөвхөн их хотуудад болон тосгон суурингуудад ханддаг төдийгүй басхүү ерөөс бүхий л эх дэлхийн тив нутгуудад энэхүү дээр дурдсан үүргийг гүйцэтгэдэг. /смодтрите: Гаспаров.М.Л. “Записи и выписки” /Новое литературное обозрение. 1998. № 6. /34/.с.446./

Утга зохиол шинжлэлийн орон нутгийн мэдлэг гэдэг бол: зохиолчдын намтрын судалгаа, эх бичвэр судлал дээр суурилсан эхийн хэвлэлүүд, тайлбарууд, утга зохиол - уран сайхны бүтээлүүдийг сэдэв болон дэвшүүлсэн асуудлаар нь ангилсан ангилал, тэдгээрийн бүтэц-туувилзүйн задлан шинжилгээ зэрэг олон олон хүчин зүйл дээр нь тулгуурлан тухайн бүс нутгийн өвөрмөц амьдралыг танин мэдэх нэг арга зам юм. Хэл бичгийн нутгархал судлалын практик үйл ажиллагааны явцад утга зохиолын бүтээлүүдийн тухай болон бүтээлч бие хүмүүс болох тэдгээрийн зохиогчдын тухай тэрчлэн түүхэн хөрөг дүрүүд болон өөр бусад зах хязгаар нутгуудын талаарх алдар цуутай болсон тайлбаруудад нэмэлт оруулах, шинэ мэдээлэл бүтээх бололцоо олддог. Энэ үед зах хязгаар нутаг орны тухай зохиолчдын өөрсдийнх нь дүгнэлт, бүдэг бадаг тайлбар төдийхөн хангалтгүй бөгөөд харин тус тусдаа өөр өөр тохиолдлууд болон өөр өөр нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагатай. Учир нь тус тусдаа тохиолдлуудад болон өөр өөр нөхцөл байдал дунд өөр тодорхойлолт өөр дүн шинжилгээ төрөн гардаг жамтай. Тиймээс чухам яг тэр тухайн цаг мөчид, тухайн нөхцөл байдал дунд л асуудал илүү тодорч, ойлгомжтой болдог, яагаад гэвэл жишээ нь А.Платонов 1920-иод оны II хагасын Тамбовын амьдралыг нэгэн утгаар шууд сөрөг гэж дүгнэсэн бол О.Мандельштам 10 жилээс багагүй хугацаагаар ганцаараа Тамбовт өвлийн магтаал хоолойгоо сөөтөл дуулсан билээ.

Өнөө үед бүртэр байтугай бүс нутгийг шинжлэх ухаанч байдлаар бүх талаас нь танин мэдэх талаараа тэргүүлэх байр суурьтай судалгааны аргазүйд ч, заримдаг шинжтэй, агуулгын хувьд зөрүүтэй, шинжлэх ухааны зарчмуудад огт хавьтахааргүй тодорхойлолтууд нэлээд тааралдах болжээ. Орон нутгийн мэдлэг: энэ бол зөвхөн судалгааны үйл явц төдийгүй хүмүүнлэгийн ухааны хил хязгаарын буюу захын салбар юм. Энд зах хязгаар нутгийн амьдралыг судлахад хандсан шинжлэх ухааны хавсарга болон захын дагалдах шинжийн тухай яриа болж байна: энэ тохиолдолд “орон нутаг судлал”, “орон нутгийн мэдлэг”, “бүс нутгийн нутгархал судлал” хэмээх ойлголтууд нь

хоорондоо зарчмын хувьд адил төстэй, тэнцүү байдалтай. Харин дараах зүйлийг цохон тэмдэглэх нь чухал: үүнд бодит амьдрал дээр тэрчлэн уран сайхны ертөнцөд эдгээр ойлголтууд нь тус тусдаа болон хамтдаа өөрсдийнхөө үүргийг гүйцэтгэдэг бөгөөд тэд олон утгатай, олон үүрэгтэй, нийлэг шинжтэй /синкретичны/, бүгдээрээ л зах нутгийн судалгаанд чиглэгддэг, хоорондоо солбилцдог, гэвч бүгдээрээ бие биенээсээ ямар ч хамааралгүй байдаг. Бүс нутаг судлал буюу нутгархал судлал нь хүмүүнлэгийн ухааны нэг салбар бөгөөд зах хязгаар нутгийн өвөрмөц онцлогийг танин мэдсэний үндсэн дээр шинжлэх ухааны шинэ, нарийвчилсан мэдлэгийг хүлээн авах, өөрийн болон шинжлэх ухааны бусад салбарын хүрээнд гарч буй шинэ шинэ нээлтүүдийн нууцад нэвтрэх, танин мэдэх, ойлгож ухамсарлах эрмэлзэл тэмүүлэл бүхий хоёр талт давхар давхар ач холбогдол бүхий үйл ажиллагааны нэг чиг шугам юм.

Жишээ нь: Достоевскийн романууд болон Блокийн “Арван хоёр” найраглал тэрчлэн Пушкины “Бяцхан эмгэнэл”-ийг ойлгохын тулд Петербургийн түүх судлалаар дамжуулан хэлбичгийн ухаанд болон утга зохиол шинжлэлийн нутгархал судлалд хандаж болно. Хамгийн гол нь эргэх холбоо: өөрөөр хэлбэл утга зохиолын мэдлэгээс түүхэн баримтыг тогтооход чиглэгдсэн бусах холбоо юм.

Бүс нутаг судлал буюу нутгархал судлалын /регионалистика/ орон нутаг судлалаас /краеведение/ ялгагдах ялгаа нь угсаатны, үндэстний, сэтгэл судлалын болон соёл судлалын тэрчлэн улс төр - үзэл баримтлалын асуудлуудыг оруулах замаар судалгааны хүрээг өргөжүүлж, хэргийн учрыг илүү өндөр төвшинд, өргөн хүрээнд авч үзэх хэрэгтэй байдагт оршино. Нутгархал судлал нь тодорхой асуудлуудад нэлээд бодлогын шинжтэй дүгнэлт дэвшүүлдэг бөгөөд түүхийн болон түүхэн шинжтэй баримтуудыг зохих, зөв байр сууринд нь тавьж чаддаг. Шинжлэх ухааны болон шинжлэх ухааны хялбаршуулсан утга зохиолд “утга зохиол шинжлэлийн орон нутаг судлал” хэмээх агуулгын хүрээ хязгаар нь тодорхой бус нэр томъёог ашигладаг бөгөөд энэхүү орон нутаг судлал нь зөвхөн “утга зохиолын дурсгалууд болон түүхэн үйл явдлыг бодитойгоор тайлбарлах үзэл” дээр төдийгүй юуны өмнө орон нутгийн утга зохиолын амьдралын ерөнхий дүр зургийн судалгаан дээр үндэслэдэг. Чухамхүү ийм нэрээр “Утга зохиолын товч нэвтэрхий толь бичиг”-т тусгай өгүүлэл оруулсан байна. /Кайев. А. “Литературоведческое краеведение” /”Краткая

литературная энциклопедия” Т. 4. М. “Советская энциклопедия” М. 1967. С.385 – 386/

Хэл зохиолын нутгархал судлал нь дан ганц шинжлэх ухаан ч биш бөгөөд энэ тухай Д.С.Лихачев судлагдаж буй, үгээр биежсэн үзэгдлүүдийн өөрчлөлтийн бодит жишээ болсон тийм бүс нутгийн амьдрал, түүний судалгааны объектууд, баримт сэлтийг нэгтгэн дүгнэсэн “Утга зохиол шинжлэлийн нарийн тодорхой байдлын тухай өгүүлэх нь”, “янз бүрийн шинжлэх ухааны бүрдэл” хэмээх судалгааны ажилдаа утга зохиол шинжлэлийн тухай ерөнхийдөө тайлбарласан байдаг. Энэ нь нэг талаасаа маш олон талын мэдээллийг өөртөө шингээн илэрхийлж чаддаг түүхийн тийм бодит дүрүүдийг дотроо тээж явдаг бөгөөд нөгөө талаас утга зохиолын түүх /история литературы/, эх бичвэр судлал /текстология/, үйл явдлын тогтолцоо судлал, /сюжетология/, тайлбарлал зүй /герменевтика/, харилцан шүтэлцээ судлал /диалектология/, когнитив хэл шинжлэл /когнитивная лингвистика/ болон хэл бичгийн ухааны /филологическая наука/ бусад салбаруудын нэг ёсондоо “барилгын материал” нь болж байдаг билээ.

Утга зохиол шинжлэлийн бүс нутаг судлал буюу нутгархал судлал нь уран зохиолын элдэв үзэгдлүүдийг судлах үйл ажиллагааг идэвхтэй санал болгож байдаг. Зохиолчдыг сонгох шалгууруудыг боловсруулах явцад тэдний зохиол бүтээлүүдийг нэг сэдэвт дагнасан судалгааны ажилд зориулан түүх - утга зохиолын зүй тогтлын дагуу тэдгээрт буй түүхэн баримтуудыг нээн илрүүлэх зорилгоор энэхүү нутгархах үзэл судлал нь юуны өмнө утга зохиол - уран сайхны сонгодог танилцуулдаг, өөрөөр хэлбэл утга зохиолын түүхэн дэх тэдний үе болоод тэднээс бусад цаг үеийн сонгодог уран бүтээлчид тэрчлэн сонгодог зохиол бүтээлүүдийг тодорхойлж, үндэсний соёл дахь томоохон чиглэлүүдийг ерөнхийдөө тодотгож байдаг бөгөөд мөн нэгэнт хуримтлагдсан уран сайхны “өв хөрөнгө” /”капитал”/ болох баялаг суурин дээр уламжлал шинэчлэлийн шийдлүүд батжин бэхжихэд үйлчилдэг.

Гэхдээ хүмүүнлэгийн ухааны нэг салбар болох утга зохиол шинжлэлийн нутгархах үзэл судлал хэлбэржин тогтох замд мэдэгдэхүйц саад бас тулгардаг: учир нь шинжлэх ухааны утга зохиолд ерөөс утга зохиолын ертөнцөд “сонгодог” хэмээх ойлголт нь цаг ямагт маргаан дагуулж байдаг бөгөөд үргэлж маргаантай хэвээр үлддэг. /смотрите: Сент - Бев. Ш. “Литературные портреты”. Критические очерки. М. ГИХЛ. 1970. С. 310, Кормилов.С.И. “О соотношении

литературных рядов” /опыт обоснования понятия/ Известия Академии Наук. Серия литературы и языка. Т.60.2001. № 4. С. 310. Полякова.Л.В. “Что такое классик?” К проблеме соотношения “литературных рядов” /Полякова.Л.В. “Теоретические и методологические аспекты истории русской литературы 20 - 21 веков” Тамбов: Пролетарский светоч. 2007. С. 116 - 136/

Тухайлбал энэ талаар өөрөөр хэлбэл утга зохиол - уран сайхны сонгодгууд болон утга зохиол шинжлэлийн сонгодгуудыг танилцуулсан Д.Московскойн “1920 - 1930-аад оны Оросын утга зохиол дахь уран сайхны газар орон судлал ба Н.П.Анциферов. Оросын утга зохиол ба орон нутаг судлалын хоорондын харилцаа холбооны асуудалд” хэмээх ганц сэдэвт зохиол /М.ИМЛИ. 2010/ мөн “1920 - 1930-аад оны Оросын утга зохиол ба утга зохиол шинжлэл дэх Н.П.Анциферовын хэсэгчилсэн түүхэн арга” хэмээх докторын зэрэг горилсон диссертаци хэвлэгдэн гарсан байна. Эдгээр нь орчин үеийн утга зохиол шинжлэлд ихээхэн ач холбогдол бүхий үйл явдал болсон юм. Зохиолч Н.П.Анциферовын шинэчлэгч зарчимууд болох шинэ үзэл санааг задлан шинжилсэн төдийгүй бас хэдийгээр Анциферов энэ нэр томъёог хэрэглээгүй ч гэсэн хэлбичгийн нутгархал судлалыг онолын хувьд үндэслэсэн билээ. / тэрээр тухайн цагтаа тийм ч их амжилттай байж чадаагүй бөгөөд түүнийг “орон нутаг судлаач хэл шинжлэлтэн” гэж дооглон нэрлэдэг байв/

Д.Московскойн бичсэн ажлуудад утга зохиолын түүхэн хандлагын өвөрмөц арга барилын үүднээс утга зохиол шинжлэлийн сэтгэлгээний түүхэн дэх сонгодгуудыг онцгойлон чухалчилж үзсэн бөгөөд орчин цагийн утга зохиол шинжлэлийн арга зүйд Анциферовын хэсэгчилсэн түүхэн судалгааны арга зүйг бүрэн дүүрэн ашиглаж чадсан юм. Энэ хандлагад дээр нэр дурдсан диссертацийн “Н.П.Анциферовын утга зохиол шинжлэл дэх хэсэгчилсэн түүхэн арга. Шинжлэх ухааны урьдчилсан нөхцөл, баримжаа. Агуулга.” хэмээх нэртэй 2-р бүлэг онцгой үнэ цэнэтэй судалгаа болсон юм. Энэ хэсэгт уран сайхны дүрүүдийн талаарх албан ёсны бус анхдагч аман эх сурвалжуудыг задлан шинжлэх, нэр томъёог ашиглах зэрэг онол - арга зүйг тодорхойлон гаргасан юм. Д.Московская өөрөө энэхүү аргагүйгээ Добычин, Золотарев, Заболоцкий, Вагинов, Платонов нарын уран бүтээлийн өв санг судлахдаа амжилттай ашигласан билээ. Ингэхдээ тэрээр Вагиновын “Ленинградын үлгэрүүд” зохиолын төгсгөлийн хэсэг, Заболоцкийн “Зурвас цуваа” зохиолын Ленинградын дүр зэргийг

судлахдаа “Үхлийн тухай мэдэгдэл” хэмээх жүжиг болон “Турбиныхан” кино зохиолын талаарх Платоновын тэмдэглэлүүд дэх байгал - архитектурын төрх байдлын ач холбогдол, тэрчлэн Добычины “Н хотод” /”В городе Эн”/ зохиолууд дахь зохиогчийн үнэ цэнэт байр суурь зэрэг асуудлуудыг авч үзээд Д.Московской дараах зүйлийг тэмдэглэсэн. Үүнд: Анциферовын онол нь түүний үеийн нэртэй судлаачдын үндэслэсэн цаг хугацаа - орон зайн нэгдлийн /хронотоп/ тухай сургаалтай зарим талаараа зөрчилдсөн бөгөөд “... Бахтинд байдаг нийгмийн бодит байдлын сэтгэлгээ нь ямар ч байсан соёл судлалын болон философи - гоозүйн асуудлуудын хүрээнд үлдэнэ, харин тэгэхэд Анциферовын арга нь судлаачдыг уран сайхны дүрийн албан бус анхдагч эх сурвалжуудад шууд буцааж аваачдаг.” /Московская.Д.С. Указ.соч. с. 57/

Тэрчлэн Д.Московской зориуд хэрэг болгож Анциферовын хэсэгчилсэн - түүхэн аргагүйн агуулгын онцлогийг тодорхойлсон бөгөөд зохиолчдын тэрчлэн орон нутаг судлаач - нийгмийн түүхчдийн авьяас билэг, хүчин чармайлтын ачаар бүтэж буй болсон утга зохиол болох Оросын утга зохиолын онц чухал өвөрмөц шинжүүдийг нээн илрүүлсэн Анциферовын утга зохиолын - түүхэн судалгааны тухай бичсэн байна. Д.Московская тэрчлэн Оросын үгийн урлаг дахь орон зай - цаг хугацааны нэгдмэл байдалд оршдог дүрт шинжийг мөрдөн мөшгиж нийгмийн ажиглалт, урьдчилсан дүн шинжилгээ, таамаглал зэргийн жинхэнэ үнэн учрыг үзүүлэн таниулсан юм. “Тэгэхээр Анциферов ямар учраас утга зохиолын түүхийг судлах нь утга зохиол судлаачийн зүгээс албан бус эх сурвалжуудын бодол сэтгэгдэл, түүхийн тодорхой мэдлэг зэргийг шаарддаг гэж үзэж байсан бэ? Ер нь эцсийн дүндээ аливаа судлаач хүн түүний өмнө бодит байдал нээгдэн тодрох үед даруу төлөв үзэл бодолтой байж л оюун санааны дадал зуршлаар төрөн гарч ирдэг шинжлэн судлагч хүний амиа бодсон явцуу үзлийг даван туулдаг чаддаг гэж энэ эрдэмтэн итгэж байсан билээ.” /там же. С. 10/

Ингээд эцэст нь Д.Московская ямар ч гэсэн утга зохиолын түүхчид хэсэгчилсэн - түүхэн аргын ач холбогдлыг нэлээд туйлшруулж байна гэж үзсэн. Шинжлэх ухааны тодорхой судалгаа шинжилгээ бодитой урагшлахын хэрээр аливаа эргэлзээ тээнэгэлзэл багасч нарийн ширийн зүйлс тодрон тайлбарлагдах ёстой. Тухайлбал, хэл бичгийн бүс нутаг судлал буюу нутгархал судлалд энэхүү арга нь үндсэн, суурь арга байх бололцоотой. Харин аливаа зохиолын уран сайхны үнэ цэнийг зөвхөн

тухай зохиол бүтээлийн өөр өөр хэсгүүдийн “гинжин холбооны үр дүн”, энэхүү холбооны хөдөлгөөнт тогтолцоог иж бүрэн задлан шинжлэх аргыг ашиглаж л судлаж болно. “Нутаг орны зүйн уран дүрслэл”-ийн /”местнографической образности”/ задлан шинжилгээний арга нь өөрийн гэсэн зорилттой байдаг бөгөөд за тэгээд өөр бусад аливаа арга шиг уран сайхны бүтээлийн бүх баялаг сайхан шим шүүс бүхнийг шавхан дуусгаж хэрхэвч болохгүй билээ.

Утга зохиол шинжлэлийн бүс нутаг судлал буюу утга зохиол шинжлэлийн нутгархах үзэл судлал- /литературоведческая регионалистика/-ын хөгжил, төлөвшилд соёл - түүхийн дэг сургууль /культурно - историческая школа/, юуны өмнө Н.Тихонравов болон А.Пыпина нар үлэмж үүрэг гүйцэтгэсэн. Тихонаравовын шавь нарын нэгний дурсамжаар бол энэхүү нэрт орон нутаг судлаачийн лекц дээр “захидал, дурсамж, намтар, тэмдэглэл, гар бичмэл, эх ноорог, цоморлог гэх мэт утга зохиолын элдэв дурсгалуудын талаар тал талаас нь үг үсэгчлэн байцаах явдал байнга тохиолддог байжээ. Баримт болгоныг өөр бусад баримтуудаар нягтлан шалгаж үздэг, бүр өчүүхэн жижиг хэсгийг ч хатуу ширүүн шалгуураар шүүж үзэлгүйгээр тойрч гардаггүй байсан байна.” (Милонов,х.25). Ийнхүү Анциферовын судалгаанд утга зохиол шинжлэлийн талбар дахь хэл зохиолын нутгархал судлалын олон хүчин зүйл бүхий дүр төрхийн алгасалт давтамжуудыг /алгоритм/ нийлүүлэн дурдсан байдаг бөгөөд судлагдахуун болон судалгааны арга зүйг нь тодорхой болгон, эрдэм шинжилгээний арга барилуудыг нь боловсронгуй болгосон байна. Өнөөдөр энэхүү арга барил, үзэл баримтлалууд нь онолын цаашдын тодруулга төгөлдөржилтөд ашиглагдаж, практик амьдралд судалгааны эрхэм жишээ болон нэвтэрсээр байна.

Орчуулсан: С.Энхбаяр, профессор, МУБИС